

"ДОРНОД БҮСИЙН ЭРЧИМ ХҮЧНИЙ СИСТЕМ" ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2024 оны 04 сарын 29 өдөр

Дугаар № 06

Улаанбаатар хот

2024 оны ногдол ашгийн тухай

Компанийн тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.8 дахь заалтыг үндэслэн Хувьцаа эзэмшигчдийн хурлаас ТОГТООХ нь:

1. "Дорнод бүсийн эрчим хүчний систем" төрийн өмчит хувьцаат компанийн 2023 оны жилийн эцсийн аудитлагдсан санхүүгийн тайлангаар 4,879,141,194.88 /дөрвөн тэрбум, найман зуун далан есөн сая, нэг зуун дөчин нэгэн мянга, нэг зуун ерэн дөрвөн төгрөг наян найман мөнгө/ төгрөгийн цэвэр ашигтай ажилласан тул цэвэр ашгийн дүнгээс 15 хувиар тооцож 731,871,179.24 /долоон зуун гучин нэгэн сая, найман зуун далан нэгэн мянга, нэг зуун далан есөн төгрөг хорин дөрвөн мөнгө/ төгрөгийн ногдол ашиг хуваарилахыг зөвшөөрсүгэй.

2. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Аудитын хороонд даалгасугай.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ИТГЭМЖЛЭГДСЭН ТӨЛӨӨЛӨГЧ

ЭРЧИМ ХҮЧНИЙ ЯАМЫГ
ТӨЛӨӨЛЖ:



Н.ТАВИНБЭХ

ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫГ
ТӨЛӨӨЛЖ:



Ц.БАЯР-ӨРДЭНЭ

"ДОРНОД БҮСИЙН ЭРЧИМ ХҮЧНИЙ СИСТЕМ" ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2024 оны 14 сарын 04 өдөр

Дугаар № 05

Улаанбаатар хот

Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны зардлын төсөв батлах тухай


"Компанийн тухай хууль"-ийн 62 дугаар зүйлийн 62.1.13 дахь заалтыг үндэслэн
ТОГТООХ нь:

1. "Дорнод бүсийн эрчим хүчний систем" төрийн өмчит хувьцаат компанийн
Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны зардлын төсвийг хавсралтаар баталсугай.

2. Батлагдсан төсвийн зарцуулалтад хяналт тавьж ажиллахыг Төлөөлөн
удирдах зөвлөлийн дэргэдэх Цалин урамшууллын болон Аудитын хороодод тус тус
даалгасугай.


ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ИТГЭМЖЛЭГДСЭН ТӨЛӨӨЛӨГЧ

ЭРЧИМ ХҮЧНИЙ ЯАМЫГ
ТӨЛӨӨЛЖ:



Н.ТАВИНБЭХ


ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫГ
ТӨЛӨӨЛЖ:



Ц.БАЯРЭРДЭНЭ

ATA11111 8023169 9023120316

“Дорнод бүсийн эрчим хүчний систем” ТӨХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын 2024 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийн 05 дугаар тогтоолын хавсралт



ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
2024 ОНЫ ЗАРДЛЫН ТӨСӨВ

/мян.төг/

№	Зардлын төрөл	Тоо	Нэгжийн зардал	Сарын дүн	Дүн
1	ТУЗ-ийн дарга	1	1,300.0	1,300.0	15,600.0
2	ТУЗ-ийн гишүүд, нарийн бичгийн дарга	9	1,200.0	10,800.0	129,600.0
	Цалингийн дүн			12,100.0	145,200.0
3	НДШ			1,404.0	16,848.0
4	Бичиг хэргийн зардал				500.0
5	Хурал зохион байгуулах зардал				706.8
6	Томилолтын зардал				6,100.0
	НИЙТ ДҮН				169,355.0

"ДОРНОД БҮСИЙН ЭРЧИМ ХҮЧНИЙ СИСТЕМ" ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2024 оны 04 сарын 29 өдөр

Дугаар № 07

Улаанбаатар хот

Гүйцэтгэх захирлын Онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээг дүгнэх тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.15 дахь заалт, 84 дүгээр зүйлийн 84.4 дэх хэсэг, Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 345 дугаар тогтоолын 1.1 дэх хэсэг, Хувьцаа эзэмшигчдийн хурлын 2022 оны 04 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан "Эрчим хүчний салбарын төрийн өмчит компанийн Гүйцэтгэх захиралтай байгуулсан Онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээг дүгнэх түр журам"-ын 2.7, 2.8, 2.9, Эрчим хүчний сайдын 2024 оны 03 дугаар сарын 07-ны өдрийн А/76 дугаартай тушаалаар байгуулагдсан Ажлын хэсгийн дүгнэлтийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. "Дорнод бүсийн эрчим хүчний систем" төрийн өмчит хувьцаат компанийн Гүйцэтгэх захирал Г.Отгонбаатартай байгуулсан 2023 оны Онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээний биелэлтийг 71 оноогоор "Хангалттай" гэж дүгнэсүгэй.


2. "Дорнод бүсийн эрчим хүчний систем" төрийн өмчит хувьцаат компанийн Гүйцэтгэх захирал Г.Отгонбаатартай Онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээг энэхүү тогтоол батлагдсан өдрөөс эхлэн 1 (нэг) жилийн хугацаатай байгуулахыг компанийн Төлөөлөн удирдах зөвлөлд төрийн өмчийн төлөөлөл хэрэгжүүлж буй гишүүдэд удирдамж болгосугай.

3. Компанийн 2024 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний төлөвлөгөөг үзүүлэлт бүрээр ханган биелүүлэх, борлуулалтын орлогыг нэмэгдүүлэх, өртөг зардлыг бууруулах, үйлдвэрлэлийн үр ашгийг нэмэгдүүлэх, өр авлагыг барагдуулах талаар шаардлагатай арга хэмжээг авч ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлд үүрэг болгосугай.


4. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хувьцаа эзэмшигчдийн хурлын нарийн бичгийн дарга нарт үүрэг болгосугай.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ИТГЭМЖЛЭГДСЭН ТӨЛӨӨЛӨГЧ

ЭРЧИМ ХҮЧНИЙ ЯАМЫГ
ТӨЛӨӨЛЖ:


Н.ТАВИНБЭХ
УХА053

ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫГ
ТӨЛӨӨЛЖ:


Ц.БАЯР-ЭРДЭНЭ
07-117 07-701 3